



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Эрдэнэт төгөл” ХХК-иас борлуулалтын авлагын дүнд үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө тооцуулан авахыг дэмжих тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.16, 9 дүгээр зүйлийн 9.3.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт төгөл” ХХК-тай 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 2016/1-53 дугаартай захиалан бариулах гэрээний дагуу худалдан борлуулсан “Буянт-Ухаа 2” хорооллын 193 дугаартай 272 м.кв үйлчилгээний төвийн барилгын суурийн гэрээний үлдэгдэл төлбөр болох 256,500,000 төгрөгийн авлагын дүнд тухайн суурин дээр баригдсан үйлчилгээний төвийн 5 давхар барилгаас 84 м.кв талбайг 352,800,000 төгрөгөөр тооцож шилжүүлэн авахыг дэмжсүгэй.

2. Үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгө шилжүүлэн авах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, биелэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Эрдэнэбулган/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга /Л.Амгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ШИНЭХҮҮ